



Агуйд Баригдсан нь

ЭВ НЭГДЭЛ Бид бие биенээ хүндэлдэг.

Унших Зүйл

1 Самуел 18:5-9; 19:1,2,11,12; 24:1-22; *Эцэг Өвгөд ба Зөнчид*, х. 649-663.

Цээжлэх Ишлэл

“Сайныг үйлдэхдээ зүрхшээхгүй байцгаая” (Галат 6:9).

Зорилго

Хүүхдүүд дараах зүйлст суралцана:

Их Эзэн хүн бүрийг үнэлдэг гэдгийг **мэдэх** болно.

Бусдын төлөө сайныг хийх хүсэл **эрмэлзэлтэй** болно.

Хүмүүс тэдэнтэй найрсаг биш байлаа ч тэд хүмүүстэй сайхан **харьцах** болно.

Гол Санаа



Бусад хүмүүс бидэнд сайн биш байсан ч бид сайныг хийж чадна.

Хичээлд Бэлтгэх нь

Библийн Хичээлийн Товчлол

Давид Их Эзэнээр ивээгдэж хэзээ нэгэн цагт хаан болно гэдгийг нь Саул хаан мэдсэн учраас түүнд ихэд атаархаж байлаа. Саул хаан Давидыг хайж хороохоор ирж байгааг Давид болон түүний цэргүүд хараад тэд агуйд нуугдана. Саул хаан агуйд орсон боловч Давид болон түүний хүмүүсийг олж харсангүй. Тэр үед Давидад Саул хааныг хороох боломж байсан хэдий ч тэр түүнийг хөнөөсөнгүй. Харин Давид Саул хааны нөмрөгнөөс хэсгийг тайран авчээ. Саул хааныг агуйгаас гарсны дараа Давид түүнд Их Эзэн таныг хаан хэмээн сонгосон учраас би

хороож үл чадна гэдгээ чанга дуугаар хэлсэн. Тэр үед Саул хаан Давидыг өөрөөсөө илүү ухаалаг гэдгийг мэдээд цэргүүдээ аван орхин одов.

Энэ бол эв нэгдлийн тухай хичээл

Саул хаан өөрийг нь үзэн ядаж байсан ч Их Эзэн Саулыг Израилийн анхны хаанаар сонгосон учраас Давид түүнд үргэлж хүндэтгэл үзүүлж байлаа. Тиймээс хэдийгээр бусад хүмүүс бидэнд тааламжтай бус хандсан ч бид тэднийг үргэлж хүндлэх ёстой. Учир нь тэд ч мөн Их Эзэний хүүхдүүд гэдгийг санах хэрэгтэй.

ГУРАВ

Хичээлийн Төлөвлөгөө			
ХИЧЭЭЛИЙН ХЭСЭГ	ХУГАЦАА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЦЭЭТЭЙ МАТЕРИАЛ
Мэндчилгээ	үргэлжлэх	Хүүхдүүдээ угтах, тэдний сэтгэгдлийн талаар асуух	
1 Бэлтгэх Ажил	10 минут	<i>А. Онцгой Бүтээл</i> <i>Б. Зөөлөн Үлээлт</i> <i>В. Есүс Чамд Хайртай</i>	өрдөг эсвэл эвлүүлдэг тоглоом, цаас, өнгийн харандаа үлээсэн бөмбөлөг үрчгэр цаас эсвэл парлон
* Залбирал ба Магтаал*	10 минут	37-р хуудсыг үз. *Залбирал ба Магтаал -ыг хөтөлбөрийн дундуур аль ч үед хийж болно.	
2 Библийн Хичээл	20 минут	Түүхтэй Танилцах	Библийн тухайн цаг үеийн хүүхдийн болон том хүний хувцас, "агуй", даавууны өөдөс
		Библи Судлал	Библи
		Цээжлэх Ишлэл	Библи
3 Хичээлээ Заах	15 минут	<i>Их Эзэний Хүүхдүүд</i>	байхгүй
4 Хичээлээ Хуваалцах нь	15 минут	<i>Даавуугаа Хуваалцъя</i>	цэвэрхэн даавууны өөдөс эсвэл даавууны том хэсэг, хайч

Багшийн Баяжуулалт

"Израилийн хаан өөрийн үйлээ Хэмжээлшгүй нэгний эсрэг хандуулав. Саул Израилийг захирч байхдаа өөрийн сүнсийг хэрхэн захирахыг сурсангүй..."

"Их Эзэн Давидтай хамт байгаа гэдэг нь тодорхой болчихоод байхад Саул Давидыг үгүй хийх боломжийг хайсаар байлаа. Давидын гэмгүй байдал нь Саулын уурыг ихэд хүргэжээ. Саул өөрийн муу зан чанарыг Давид байгаа учраас зэмлэл буруушаал болж байна гэж боддог байжээ. Хаан ширээгээ алдахгүй гэсэн атаа хорсол нь Саулыг өрөвдөлтэй нэгэн болгодог." (Эцэг өвгөд ба Зөнчид, х. 650, 651).

Биднийг гомдоож байгаа хүмүүс Их Эзэний гэр бүл гэдгийг бид санаж байна уу? Хэн нэгэнд гомдохдоо бид ямар нэгэн хов жив үүсгэж заавал шүүмжлэлтэй хандах хэрэгтэй гэж үү?

Өрөөний Зохион Байгуулалт

1-р хичээлийг хар. Түүн дээрээ ширээ эсвэл сандлын хар, саарал, бор өнгийн бүтээлэг эсвэл жижиг майхнаар "агуй" хийгээрэй. Энэ нь ангийн тань хүүхдүүд бүгд багтахаар байх ёстой. Үүнийгээ та 7-р хичээлийн "халуун зуух", 8-р хичээлийн "арслангийн үүр", 10-р хичээлийн "Нүх" гэдэг хэсгүүд дээр хэрэглэж болно.

Заах Хичээл

Мэндчилгээ

Сурагчдаа угтан авч амралтаа хэрхэн өнгөрүүлсэн, юу сайхан байсан, юу хэцүү байсан талаар асуугаад, өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурсан зүйлээ бусадтай хуваалцахад нь урам өгөөд өөртөө тохиромжтой байдлаар хичээлээ эхлүүлээрэй.



Бэлтгэх Ажил

Анги болон нөхцөл байдалдаа хамгийн тохиромжтой хувилбарыг сонгоорой.

А. Онцгой Бүтээл

Хэрэгтэй зүйлс:

- өрдөг эсвэл эвлүүлдэг тоглоом
- цаас
- өнгийн харандаа

Өрдөг тоглоом болон эвлүүлдэг тоглоомыг ашиглан хүүхдүүдээр ямар нэгэн зүйл хийлгэж эсвэл зураг зуруулаарай. (Цөөхөн хүүхдүүдтэй ангид бүгдийг нь хийлгээрэй.) Бие биенийхээ юу хийснийг тойрон явж үзэхийг хүүхдүүдэд хэлээд хүүхэд бүр өөрийн хийсэн зүйлээ тайлбарлахыг хүсээрэй.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах хугацаа өгөөрэй: **Чи юу хийсэн бэ? Хэрвээ би та нарын хийсэн зүйлийг нураагаад эсвэл зурсан зургийг чинь урчихвал яах вэ? Хүмүүс бидэнд сайхан биш хандахад бидэнд муухай байдаг, тийм үү? Хэдийгээр хүмүүс заримдаа муухай ааштай байдаг ч Есүс хайрласаар л байдаг. Есүс хүн бүрийг онцгойгоор бүтээсэн ба биднийг бие биедээ хүндлэл үзүүлэхийг хүсэж байдаг. Бид бусдад сайхан хандсанаараа тэдэнд хүндлэл үзүүлж чаддаг. Хэрвээ хүмүүс бидэнд муухай хандахад бид ч мөн эргүүлээд муу хандаж чадах нь амархан ч Есүс биднийг найрсаг байхыг хүсдэг. Өнөөдрийн бидний үзэх Библийн түүх бол өөрт нь хэдий муу санаж байсан хүнд хүндлэл үзүүлж чадсан нэгэн залуугийн тухай юм. Өнөөдрийн хичээлийн гол утга санаа бол:**



Бусад хүмүүс бидэнд сайн биш байсан ч бид сайныг хийж чадна.

Намайг дагаад хэлээрэй.

Б. Зөөлөн Үлээлт

Хэрэгтэй зүйлс:

- хийлсэн бөмбөлөг

Хийлсэн бөмбөлөгүүдийг газар тавиад ангийн нэг талаас нөгөө тал хүртэл хүүхдүүдээр зөөлнөөр үлээлгээрэй.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах хугацаа өгөөрэй: **Бөмбөлөг үлээхэд та нарт хэцүү байсан уу? (Үгүй, Тэд шаарыг зөөлнөөр үлээсэн). Бөмбөлөгийг хөдөлгөхийн тулд та нар өшиглөх эсвэл цохих шаардлага байхгүй. Зөөлөн үлээх нь л хангалттай. Энэ бол Есүст хайртай хүмүүс бусдад яаж хандах арга юм. Тэд бусадтай эелдэг ба тэдэнтэй сайхан харьцдаг, харин хатуу ширүүнээр биш юм. Хэрвээ чи нэг хүнд сайхан хандах гэвэл чи юу**

хийдэг вэ? (найрсаг байх, хайрлах, туслах, хуваалцах гэх мэт). **Есүст хайртай хүмүүс бусдад сайхан ханддаг. Заримдаа хүмүүс хатуу ширүүн харьцахад бид ч мөн эргүүлээд яг тийм харьцах амархан байдаг. Харин тэрний оронд сайхан хандахыг Есүс биднээс хүсэж байна. Өнөөдрийн бидний үзэх Библийн түүх бол өөрт нь хорон мууг санаж байсан хүнд хүндлэл үзүүлсэн нэгэн залуугийн тухай юм. Өнөөдрийн бидний гол санаа бол:**



Бусад хүмүүс бидэнд сайн биш байсан ч бид сайныг хийж чадна.

Намайг дагаад хэлээрэй.

В. Есүс Чамд Хайртай Гэсэн Тойрог

Хүүхдүүдийг том тойрог болгон суулгаад доорхийг зааж өгөөрэй.

Нэг, хоёр. Есүс чамд хайртай.

Тоолж байгаа мэт хоёр хуруугаа гозойлгоно.

Гурав, Дөрөв.

Тоолж байгаа мэт дөрвөн хуруугаа гозойлгоно.

Тэр чамд маш их хайртай.

Тиймээ, (Хүүхдийн нэр)!

Алгаа таших эсвэл агаарт гараа

Тиймээ, (Хүүхдийн нэр)!

даллах.

Та тойргийн дунд зогсоод нэг хүүхдийн нэрийг дуудан парлонон бөмбөгөө дээш нь шиднэ. Тэгээд таны дуудсан хүүхэд бөмбөгийг авах хооронд та тэдний суудалд нь сууна. Дуудагдсан хүүхэд тойргийн голд зогсоод бусад нь дээрх хурууны хөдөлгөөнийг хийнэ. Дараа нь тойргийн дунд зогсож байсан хүүхэд бөмбөгийг шидээд дуудагдаагүй хүүхдийн нэрийг дуудаад суудалдаа сууна. Хүүхэд бүрийн нэр гартал тоглоомыг үргэлжлүүлнэ.

Хэрэгтэй зүйлс:

- үрчгэр цаас эсвэл парлон

Бататгах нь

Хүүхдүүдийн хариултыг сонсоорой: **Есүс хэнд хайртай вэ? Бид бүгдээрээ Есүсийн хувьд онцгой юм. Тэр чамд хайртай, бас чамд (Хүүхэд бүрийг заана). Яагаад гэвэл Түүний хувьд бид бүгд онцгой. Тэр биднийг бие биедээ хайр үзүүлэхийг хүсэж байна. Заримдаа хүмүүс бидэнтэй муухай харьцдаг. Тэр үед бид ч тэр хүнтэй муухай харьцахад амархан байдаг ч Есүс биднийг тэдэнтэй эелдэг харьцахыг хүсэж байна. Учир нь тэр хүмүүс ч гэсэн Есүсийн хувьд онцгой юм. Өнөөдрийн бидний үзэх Библийн түүх бол өөрт нь хорон мууг санаж байсан хүнд хүндлэл үзүүлсэн нэгэн залуугийн тухай юм. Хичээлийн гол санаа:**



Үнэнч найзууд бие биенээ хайрладаг.

Намайг дагаад хэлээрэй.

2

Библийн Хичээл

Түүхтэй Танилцах

Хэрэгтэй зүйлс:

- Библийн тухайн үеийн том хүний болон хүүхдийн хувцас
- даавууны хэсэг
- "агуй"
- хоёр том эрэгтэй хүн

Ангийн нэг буланд агуй хий (Өрөөний зохион байгуулалт гэсэн гарчигийг хар). Хүүхдүүдийг Давидын найз шиг хувцасла. Нэг том хүн Саул хаан болж, өгүүлэгч нь Давид шиг хувцаслаарай.

Түүх ярих эвэл уншиж өгөх

Өнгөрсөн долоо хоног бид Ионатаны аав Саул хаан Давидад муу зүйл учруулах гэж байсан учраас тэр хоёр өөр тийш явсан тухай үзсэн. Ард түмэн Саул хаанаас илүү Давидад хайртай байсан учраас Саул хаан Давидад атаархаж байсан тухай санаж байна уу?

Энэ долоо хоногийн бидний үзэх түүх бол Давид болон Саул хааны тухай юм. Өнөөдрийн түүхэнд (Том хүний нэр) Саул хааны дүрд тоглох гэж байна.

[Саул хаан: "Надад Давидыг олох төлөвлөгөө хэрэгтэй байна" гэж хэлээд өрөөнөөс салхи татуулан гарах болно.]

Саул хаан Давидыг хороохоор оролдож байгааг Ионатан мэдээд түүний төлөвлөгөөний талаар Давидад хэлж өгчээ. Давид найз нартайгаа хамт зугтах хэрэгтэй болсон. Одоо бүгдээрээ Давид болон түүний найз нарын дүрд тоглон нуугдацгаая. Бид хаашаа явах вэ? *[хүүхдүүдийг дагуулан хийсэн агуй руугаа орно эсвэл том майхан байвал түүн рүүгээ орно.]* Бүгдээрээ чимээгүй байх хэрэгтэй шүү. *[шивнэж ярина.]* Саул хаан биднийг сонсох ёсгүй. Тэр биднийг хайж байгаа.

[Саул хаан ирээд "Давид болон түүний найз нар хаана байна?" гэж асуугаад өрөөгөөр хайж эхлэнэ. Тэгээд агуйн үүдэнд ирж зогсоод хормойгоо дэлгэж тавина.] Саул хаан агуйн энд ирчихсэн байна. Давидын найз юу хийхийг хүсэж байгааг та нар мэдэх үү? Хэн таах вэ? *[Хариулах цаг өгөөрэй.]* Давидын найзууд Давидыг Саул хааныг хороогоосой гэж хүсэж байсан. Давидын найзууд Саул хаан Давидыг хороохоос

өмнө Давид Саул хааныг хороогоосой гэж хүсэж байсан. Харин Давидыг юу хийсэн гэж бодож байна? *[Хариулах цаг өгөөрэй.]* Саул хаан Их Эзэний хувьд онцгой гэдгийг нь Давид мэдэж байсан ба Их Эзэн Саулыг хаан болгосон. Давид Саулыг хороож зүрхлээгүй. Хэдийгээр Саул Давидад сайн хандаагүй ч Их Эзэн Саулд хайртай байсан юм.

Чимээгүйхнээр Давид мөлхөн Саулын ард очоод хутгаа гарган хормойных нь үзүүрээс тайран авжээ. Яг л хулгана шиг, тэр буцаад найзууд дээрээ ирдэг. Тэгээд Саул хаан агуйгаас гарчээ. *[Энэ хэсгийг ярьж байхдаа даавууны хэсгээс хайчлан аваарай. Тэгээд Саул агуйг орхино.]*

Хааны хормойноос авсандаа Давид санаа зовж байлаа. Энэ нь хийгээд байх тийм ч сайхан зүйл биш. Тэр Саул хаантай ярилцахыг хүссэн учраас агуйгаас гарсан. Бүгдээрээ эндээс гарцгаая.

Тэгээд Давид "Саул хаан минь, хараач. Надад таны хормойны хэсэг байна. *[Даавууны хэсгийг үзүүлнэ.]* Таныг агуйд байхад би хажууд тань байсан юм. Та намайг хороох гэж байгаатай адил би ч таныг хөнөөж чадах байлаа. Гэвч би тэгсэнгүй. Би зүгээр л хормойны чинь хэсгийг таслаж авсан юм. Намайг уучлаарай. Их Эзэн танд хайртайг би мэднэ. Их Эзэн таныг хаан болгосон ба та Түүний онцгой нэгэн билээ. Би танд муу зүйл учруулахыг хүсэхгүй байна. Та намайг хороохоор ирсэн бол би танд мууг учруулахгүй" гэж хэлжээ.

Саул хаан Давид нөхөдтэйгээ агуйн хажууд зогсож байгааг, мөн түүний гарт байсан даавууны хэсгийг хараад Саул хаан уйлж гарав. Тэр өөрийгөө Давидад зохисгүй ааш гаргасан, Давидыг сайн хүн болохыг мэджээ. Давид Саул хааныг хороож болох байсан боловч тэгсэнгүй. *[Саул хаан "Чи надад сайныг үйлджээ, харин би чамд зохисгүй хандсан байна" гэнэ.]*

Давид Саул хаанд мууг учруулж болох байсан ч оронд нь харин сайнаар

ханджээ. Учир нь Саул хаан ч бас Их Эзэний хувьд онцгой билээ.

Бататгах нь

Асуух: Хүмүүс чамд муу хандаж байсан ямар үе байна вэ? Чи тэр үед ямар байсан бэ? Хэн нэгэн чамд мууг учруулах гэж байвал чи яах вэ? (айна, гуниглана гэх мэт). Давид болон түүний найз нарт ч бас яг л ийм байсан. Гэвч Давид Саул хаанд эелдэг хандсаар байсан. Тэр Саул хаанд муу зүйл хийгээгүй.

Бидэнд муу хандаж байгаа хүмүүст эргүүлэн эелдэг хандах ямар арга байна вэ? (тоглоомоо хуваалцах, сайхан үг хэлэх, хамтдаа тоглохыг урих, цохихгүй байх гэх мэт). Заримдаа хүмүүс бидэнд муугаар хандвал бид тэдэнтэй эелдэг харьцах дургүй байдаг. Гэхдээ бид Давид Саул хаанд хэрхэн хандсаныг санах хэрэгтэй. Өнөөдрийн хичээлийн гол санаагаа хамтдаа хэлцгээе:



Бусад хүмүүс бидэнд сайн биш байсан ч бид сайныг хийж чадна.

Намайг дагаад хэлээрэй.

Библи Судлал

Хэрэгтэй зүйлс:
 Библи

Библиэ нээгээд 1 Самуел 18:5-9; 19:1,2, 11,12; 24:1-22-р ишлэлийг гаргаж харуулаарай. Дараа нь ишлэл рүү заагаад

Бурханы үг болсон Библиэс өнөөдөр унших түүх маань энэ байна гэж хэлээрэй. Тэгээд ишлэлийг чангаар мөн хэрэгтэй газар нь өөрийн үгээр нэмэлт хийн уншаарай.

Бататгах нь

Асуух: Саул хаан Давидад юу хийхийг хүссэн бэ? Давид нөхөдтэйгээ хаана нуугдсан бэ? Давидын найзууд Давидыг Саул хаанд юу хийгээсэй гэж хүссэн бэ? Харин Давид юу хийсэн бэ? Давид Саул хаантай ярилцсаны дараа Саул хаан юу мэдэрсэн бэ? Саул хаанд

ээлдэг хандах нь Давидын хувьд амархан байсан уу? Хүмүүс чамтай хатуу ширүүн харьцаж байхад чи тэдэнтэй эелдэг харьцдаг уу? Есүс чамд туслах болно. **Санагтун:**



Бусад хүмүүс бидэнд сайн биш байсан ч бид сайныг хийж чадна.

Намайг дагаад хэлээрэй.

Цээжлэх Ишлэл

Библиэ дэлгээд Галат 6:9-г гаргаад "Өнөөдрийн бидний цээжлэх ишлэл Библийн маань энэ хэсэгт байна" гээд ишлэлээ чангаар унш. "Сайныг үйлдэхдээ зүрхшээхгүй байцгаая."

Хүүхдүүдийг дээш доош нь 10 удаа үсрүүлээд асуух нь: **Та нар ядарч байна уу? Үгүй юу? Ахиад 10 удаа үсэрцгээе.** Үсэрснийхээ дараа асуух: **Одоо харин ядарч байна уу?** Хүүхдүүдийг ядарч байна гэж хэлтэл үсрүүлээрэй.

Хэлэх: **Сайныг үйлдэхдээ ядрахгүй эсвэл шантрахгүй байцгаая** гэж цээжлэх ишлэл дээр маань хэлсэн байна. Сая бид үсрээд ядарсан шигээ хүмүүст сайхан хандахаасаа ч ядарч залхаж болох юм. Гэвч Есүс бусдад эелдэг хандахыг биднээс хүсэж байна.

Дараах хөдөлгөөнийг зааж өгнө үү.

Бүгдээрээ

Бусдыг заагаад өөрийгөө заах.



сайныг үйлдэхдээ

Алгаа дэлгээд гараа алдлах.




зүрхшээхгүй

Гараа цээжин дээрээ тавиад урагш нь сунгах.



байцгаая.

Толгойгоо сэгсрэх.



Галат 6:9

Алгаа ном мэт дэлгэнэ.



Хэрэгтэй зүйлс:
 Библи

3

Хичээлээ Заах

Их Эзэний Хүүхдүүд

Хүүхдүүдийг хол зайтай зогсоогоод дараах зүйлийг уншиж байхдаа хүүхдүүдийг хөдөлгөөн хийхийг нь урамшуулаарай. Хэлэх:

- Их Эзэний хүүхдүүдээ, гараа даллаарай.**
- Их Эзэний хүүхдүүдээ, дээш доош үсрээрэй.**
- Их Эзэний хүүхдүүдээ, эргээд хар.**
- Их Эзэний хүүхдүүдээ, тэнгэрт хүрээч.**
- Их Эзэний хүүхдүүдээ, хөл дээрээ үсрээрэй.**
- Их Эзэний хүүхдүүдээ, найзыгаа тэврээрэй.**
- Их Эзэний хүүхдүүдээ, газар суугаарай.**
- Их Эзэний хүүхдүүдээ, инээмсэглээрэй.**
- Их Эзэний хүүхдүүдээ, "Амен"**

Дахин тоглох бол Их Эзэний хүүхдүүдийн хийх хөдөлгөөнийг хүүхдүүд өөрсдөө зохиог.

Бататгах нь

Асуух: **Өнөөдөр энд Их Эзэний хэдэн хүүхэд байна вэ? Хамтдаа тоолцгооё. Бид яагаад Их Эзэний хүүхдүүд гэж нэрлэгдсэнийг хэн нэгэн надад хэлж чадах уу?** (Яагаад гэвэл Их Эзэн биднийг бүтээсэн бас бидэнд хайртай. Бид Түүний хувьд онцгой юм).

Биднийг муу хүүхдүүд байсан ч Их Эзэн бидэнд хайртай гэдгийг мэдэх үү? Их Эзэн үргэлж биднийг хайрлаж байдаг. Яагаад гэвэл бид бүгдээрээ Их Эзэний хүүхдүүд бөгөөд хэдий хэцүү байсан ч биднийг бие биедээ найрсаг хандахыг Есүс биднээс хүсэж байна. Гол санаагаа санацгаая:



Бусад хүмүүс бидэнд сайн биш байсан ч бид сайныг хийж чадна.

(From Let's Play: Group Games for Preschoolers [Group Publishing, 1996], pp. 30, 31.)

4

Хичээлээ Хуваалцах нь

Даавуугаа Хуваалцъя

Хүүхдүүдийн хариултыг сонсоорой: **Саул хааныг агуйд байхад Давид юу хийсэн бэ? Тиймээ, Давид Саул хааны нөмрөгний хормойноос зүсэж авсан юм. Яг Давидын хийсэн шиг би ч бас та нарыг энэ даавууг болгоомжтой хайчлахыг хүсэж байна. Хайч болон даавууг тараан өгнө.**

- Хэрэгтэй зүйлс:**
- цэвэрхэн жижиг даавуу, эсвэл даавууны том хэсэг
 - хайч

Бататгах нь

Асуух: **Давид яагаад Саул хааны нөмрөгний хормойноос зүсэж авсан бэ? Энэ нь Давид Саул хааны хажууд байсныг батлах ба Давид түүнд муу зүйл хийж болох байсан ч тэр үүнийг хийгээгүй гэдгийг харуулах байсан. Саул хаан Давид өөрийг нь хүндэлж байгааг мэджээ. Яг Давид шиг, бүгдээрээ бусдад найрсаг хандацгаая.**

Энэ долоо хоногт даавууныхаа хэсгийг хэн нэгэнд өгөхдөө түүнд Давид болон Саул хаан хоёрын тухай ярьж өгөөрэй. Магадгүй чи үүнийг чамд муу хандсан хэн нэгэнтэй ч хуваалцаж болох юм.

Санагтун:



Бусад хүмүүс бидэнд сайн биш байсан ч бид сайныг хийж чадна.

Хичээлийн Хаалт

Бусад хүмүүс хүүхдүүдэд муу хандсан ч хүүхдүүд сайн зүйл хийхээ мартаггүйн төлөө залбираарай.

ЗАЛБИРАЛ БА МАГТААЛ



Нөхөрлөл

Хэрэв зохимжтой гэж үзвэл хүүхдүүдийн орохдоо танд хэлсэн, тэдэнд таалагдсан эсвэл таалагдаагүй зүйлүүдийн тухай бусдад нь дуулгаарай. Өнгөрсөн долоо хоногт сурсан мэдсэн зүйлсээ болон цээжилсэн ишлэлээ сэргээн давтах цаг гаргаарай. Төрсөн өдөр, тэмдэглэлт үйл явдал болон амжилт бүтээлийг тэмдэглэхээ мартауузай. Ирсэн зочиддоо онцгойлон талархаарай.

Санал болгох дуунууд

"Сайныг үйлдэцгээе" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 263*)

"Бүгдэд сайныг үйлдэцгээе" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 265*)

"Эелдэг үг" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 310*)

"Би Есүс шиг байхыг хүснэ" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 194*)

Зорилго

Хүүхдийн Үйлчлэл сэтгүүлээс түүх ашиглаарай.

Хандив

Хэлэх: **Бид Шаббат хичээлдээ өргөлөө авчирснаараа бусдад хайртайгаа харуулж чадах юм. Үүнээс болж бусад хүмүүс Есүс тэдэнд хайртайг ч мэдэх болно.**

Залбирал

Өөрт нь муу хандаж байгаа хүнд сайнаар хандахад нь Есүс хүүхдүүдэд туслах болон Есүс хүн бүхэнд хайртай гэдгийг хүүхдүүд мэддэг байхын төлөө залбираарай.

*Залбирал ба Магтаал-ын цагийг хичээлийн аль ч үед явуулж болно.

Агуйд Баригдсан нь

Унших Зүйл

1 Самуел 18:5-9;
19:1,2,11,12;
24:1-22; Эцэг
Өвгөд ба Зөнчид,
х. 649-663.

Цээжлэх Ишлэл

"Сайныг
үйлдэхдээ
зүрхшээхгүй
байцгаая" (Галат
6:9).

Гол Санаа

**Бусад хүмүүс
бидэнд сайн биш
байсан ч бид
сайныг хийж
чадна.**

Хэн нэгэн чамд муу зүйл хийж байсан уу? Чи тэр үед яасан бэ? Бидэнд хар санаж байдаг хүмүүст бид хэрхэн сайнаар хандахыг Давидын түүхээс харж болно.

Цэрэг эр уулнаас уруудан явлаа. Тэр хайрган дээр халтирсныхаа дараа тэнцвэрээ олж ядан явав. "Саул болон түүний цэргүүд ирж явна. Саул хаан олон мянган цэрэг дагуулсан байна" гэж тэр цэрэг Давидад хэллээ. (1 Самуел 24:2-г хар.)

Давид 600 залуутайгаа агуй руу хурдхан авирч гарахад агуй том бөгөөд харанхуй байв. Давид хүмүүстэйгээ том бул чулууны ард нуугдаж амьсгаагаа барихыг хичээж байна.

Давид хүмүүстэйгээ Саул хаанаас зугтаж байсан бөгөөд Саул хаан Давидыг хөнөөх гэж байгаа гэдгээ бүгдэд мэдэгдчихсэн байлаа. Яагаад? Яагаад гэвэл тэрээр дайнд оролцоод Давидыг баатарлаг гавъяа байгуулдагт нь атаархаж байжээ. Хүмүүс Давидад хайртай. Тэд бүр Давидад зориулаад дуу зохиочихсон байв. Саул хаан үүнийг тийм ч их таашаасангүй.

Гэнэт нэг хүн агуйд орж ирлээ. Маш өндөр том залуу. Тэр Саул хаан байв. Хаан эргэж агуйн үүд рүү харав. Тэр нөмрөгнийхөө хормойг арагш чулуудахад нэг цэрэг Давидад "Хараач, Их Эзэн чамд Саулыг хөнөөх боломж өглөө" гэв.

"Би чадахгүй ээ, Их Эзэн түүнийг хаан болгосон. Би түүнийг хорлож чадахгүй" гэж Давид хэлээд хутгаа гарган чимээгүйхэн Саул хаанд ойртон очоод нөмрөгнөөс нь зүсэн авав.

Давид мөн чимээгүйхэн буцаж ирээд хааны нөмрөгнөөс зүсэж авсандаа их л санаа нь зовж байлаа.

Саул агуйг орхих үед Давид түүнийг дагаж "Эзэн минь, хаан минь, миний хүмүүс болон би таныг хөнөөж чадах байлаа. Гэхдээ би таныг хэзээ ч хорлохгүй, яагаад гэвэл Их Эзэн таныг сонгосон билээ" хэмээн хашгирчээ.

"Хараач, энэ намайг тантай ойр байсан гэдгийг гэрчилнэ" хэмээгээд нөмрөгний тасархайг

үзүүлэв.

"Давид! Энэ чи мөн үү? Чи надаас илүү сайн хүн юм" гэж Саул хэллээ. Саулын хацрыг даган нулимс урсаж "Чи их нинжин сэтгэлтэй юм. Миний дараа чи хаан болно гэдгийг чинь би мэдэж байна. Зүгээр л гэр бүлд минь муу зүйл хийхгүй гэж амлаач" гэж гуйлаа.

Тэгээд Саул хаан 3000 цэрэгтэйгээ гэрлүүгээ буцлаа. Тэр өдөр Давид Саулд хэрхэн хандсан нь Их Эзэний хувьд таатай зүйл боллоо.



Дасгал Ажил



Шаббат

Энэ долоо хоногийн өдөр бүр хичээл дээр үзсэн түүхээ уншаад цээжлэх ишлэлээ давтаарай.

- Бүгдээрээ**Бусдыг заагаад өөрийгөө заах.
- сайныг үйлдэхдээ**....Алгаа дэлгээд гараа тэлэх.
- зүрхшээхгүй**Алгаа дэлгээд гараа цээжиндээ тавиад мөртэйгөө зэрэгцүүлэн урагш нь сунгах.
- байцгаая**.....Толгойгоо сэгсрэх.
- Галат 6:9**Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

Ням

1 Самуел 18:5-9, 19:1, 2, 11, 12, 24:1-22-г уншаад "Саул хаан яагаад Давидад уурласан бэ? Тэр юу хийхийг хүссэн бэ? Давид хаана нуугдсан бэ? Давид Саул хааны төлөө юу хийсэн бэ? Дараа нь Саул хаан яасан бэ?" гэж асуугаарай.

Даваа

Сандал болон том хөнжил, бүтээлгийг агуй хийхэд ашиглаад хийсэн агуйн дотроо ороод хүүхдээрээ түүхийг яриулаарай.


Хэн нэгэн танд сайхан хандсан үед та ойшоогоогүй болон танд хэн нэгэн муугаар хандахад та хэрхэн найрсаг хандаж байснаа ярилцаарай.



Мягмар

Доорх өгүүлбэрийг хүүхэдтэйгээ хамтран гүйцээгээрэй. "Есүс ээ, найрсаг хандах хэдий хэцүү боловч ". Хоёр гурван тохиолдол бичээрэй. Бусад хүмүүс хэдий муу хандсан ч хүүхэд тань тэдэнтэй найрсаг хандахад туслахын төлөө Есүсээс гуйн залбираарай.

Шаббат хичээл дээр хайчилж авсан даавууныхаа хэсгийг хүүхэд тань хэн нэгэнд өгөөд түүнд Библийн түүхийг ярьж өгөхөд нь хүүхдээ урамшуулаарай. Хэрвээ боломжтой бол, хүүхдэд тань найрсаг биш байсан хүнтэйгээ хуваалцаж болох юм.



Лхагва

Асуух нь: Чамтай муухай харьцаж байгаа хүнтэй чи найрсаг хандах амархан уу? Давидыг найрсаг байхад нь хэн тусалсан бэ? Чамайг найрсаг байхад хэн тусалж чадах вэ?

Хэрвээ танай хөршөөс хэн нэгэн хүүхэд эсвэл том хүн та нартай найрсаг биш ханддаг бол та хүүхэдтэйгээ хамтран яг өнөөдөр тэдэнд ямар нэгэн сайн зүйл хийж өгөөрэй.

Пүрэв

Бие биедээ сайныг үйлдэж байгаа 2 хүүхдийн зураг зураад сайныг үйлдэх тухай дуу дуулаарай.

Баасан

Мягмар гарагт хийсэн "найрсаг хандах хэдий хэцүү боловч" гэсэн жагсаалтаа эргэн нэг хараад энэ долоо хоногт хүүхдийнхээ ямар байсан юу мэдэрч байсан тухай ярилцаарай. Есүст тусалсанд нь талархаарай.

Гэр бүлийн залбирлын үеэр, *Эцэг Өвгөд ба Зөнчид* номын 660-662-р хуудсыг уншаад ярилцаарай.